| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 775,000,000.00          |
| <b>I</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>1,929,454,323.85</b> |

|             |  |                         |
|-------------|--|-------------------------|
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>1,929,454,323.85</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 474,337,500.95          |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,111,991,882.90        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 343,124,940.00          |
| 131107      | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого  |                         |
| <b>III</b>  | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  |                         |
| 9           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |                         |
| 10          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | 104,127,339.06          |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн өртгийг бодит үнэ цэнээр бүртгэх, гэрээний хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор Н.Нямсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа хэрэгжүүлсэн.

Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 01/97 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хавдар судлалын үндэсний төв нь хавдрын оношилгоо, шинжилгээнд шинжлэх ухааны шинэ дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлж, хавдрын урьдчилан сэргийлэл, эрт илрүүлэлтийг сайжруулах замаар хавдрын шалтгаант нас баралтыг бууруулж, хүн амын амьдралын чанарыг сайжруулах эрхэм зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоол “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцсэн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Бодлогын баримт бичигт байгууллагын ЭМДС-ийн санхүүжилтээс үүссэн зөрүү болон орлогын бүртгэл, бараа материалын зайлшгүй байх нөөц, дотоод хяналтын талаар нарийвчлан тусгасан зүйлгүй байна.

Тус байгууллагын дотоод аудитын чиг үүргийг чанар, дотоод хяналтын албанаас хэрэгжүүлж, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн боловч тус төвийн удирдлагаар хянан баталгаажуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хавдар судлалын үндэсний төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 33,302,666.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 499,540.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг 75 хувиар буюу 374,655.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 45,751,272.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 686,269.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75.0 хувиар буюу 514,701.8 мянган төгрөгөөр тогтоов. Энэ нь ХСҮТ-ийн тайлант оны санхүүгийн тайланд аудит хийж байгаатай холбоотой материаллаг байдлыг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин тогтоох шаардлагатай гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,788,809.4 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

|                                 | /мянган төгрөг/     |                     |                    |
|---------------------------------|---------------------|---------------------|--------------------|
| Үзүүлэлт                        | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт           |
| Б                               | 1                   | 2                   | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                  | 0.0                 | 160,330.6           | 160,330.6          |
| Авлага                          | 90,895.9            | 7,972,450.6         | 7,881,554.7        |
| Бараа материал                  | 2,581,052.6         | 3,472,818.4         | 891,765.8          |
| Үндсэн хөрөнгө                  | 48,376,831.6        | 47,231,989.9        | (1,144,841.7)      |
| <b>Нийт хөрөнгө</b>             | <b>51,048,780.1</b> | <b>58,837,589.5</b> | <b>7,788,809.4</b> |
| Өр төлбөр                       | 10,936.0            | 4,804,188.6         | 4,793,252.6        |
| Засгийн газрын оруулсан капитал | 18,948,084.4        | 18,948,084.4        | 0.0                |
| Хуримтлагдсан үр дүн            | 21,088,325.6        | 24,084,106.8        | 2,995,781.2        |

|   |                     |                     |                    |
|---|---------------------|---------------------|--------------------|
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                  | 11,001,434.2        | 11,001,209.7        | (224.5)            |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>51,048,780.1</b> | <b>58,837,589.5</b> | <b>7,788,809.4</b> |

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 160,330.6 мянган төгрөгөөр өссөн нь тус эмнэлэг тайлант онд гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэнтэй холбоотой мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй;
- Авлага дансны эхний үлдэгдэл 90,895.9 мянган төгрөг нь урьд оны Сангийн яамны татан төвлөрүүлсэн мөнгийг тайлант онд барагдуулсан. Тайлант оны эцсийн үлдэгдэл 7,972,450.6 мянган төгрөг нь ЭМДС-аас авах үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлагыг бүртгэсэн;
- Бараа материалын данс тайлант онд худалдан авч зарцуулсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, урвалж оношлуурын зарцуулагдаагүй үлдэгдлээр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгийн данс ТӨБЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 446, 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 462 дугаар тогтоолоор 1,418,852.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан.
- Хуримтлагдсан үр дүнгийн данс тайлант оны үр дүнгээр 2,995,781.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт*

| Үзүүлэлт   | Өмнөх он            | Тайлант он          | /мянган төгрөг/     |
|--|---------------------|---------------------|---------------------|
|  |                     |                     | Өөрчлөлт            |
| Б  | 1                   | 2                   | 3=2-1               |
| Үндсэн үйл ажиллагааны орлого                            | 4,194,306.4         | 745,015.0           | -3,449,291.4        |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө                | 9,610,279.4         | 4,723,600.8         | -4,886,678.6        |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал                | 204,086.3           | 1,200,224.4         | 996,138.1           |
| Төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого        | 235,321.8           | 233,392.5           | -1,929.3            |
| ЭМД-ийн санхүүжилт                                       | 12,077,195.6        | 39,998,010.6        | 27,920,815.0        |
| Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 320,847.1           | 1,846,586.0         | 1,525,738.9         |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                        | 15,464,148.9        | 0.0                 | -15,464,148.9       |
| <b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>                       | <b>42,106,185.5</b> | <b>48,746,829.3</b> | <b>6,640,643.8</b>  |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 8,935,769.9         | 9,973,158.7         | 1,037,388.8         |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,200,924.7         | 1,383,788.0         | 182,863.3           |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 736,411.9           | 734,119.2           | -2,292.7            |
| Хангамж, бараа материалын зардал                         | 637,086.7           | 509,373.4           | -127,713.3          |
| Нормативт зардал   | 15,374,160.0        | 24,929,496.7        | 9,555,336.7         |
| Эд хогшил, урсгал засварын зардал                        | 1,029,496.0         | 603,237.3           | -426,258.7          |
| Томилолт, зочны зардал                                   | 19,653.0            | 49,778.1            | 30,125.1            |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 188,791.3           | 134,514.0           | -54,277.3           |
| Бараа, ажил үйлчилгээний бусад зардал                    | 4,826,505.2         | 6,659,207.1         | 1,832,701.9         |
| Урсгал шилжүүлэг   | 353,867.4           | 774,600.0           | 420,732.6           |
| <b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>                       | <b>33,302,666.1</b> | <b>45,751,272.5</b> | <b>12,448,606.4</b> |

Үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 3,449,291.4 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалаас санхүүжихтэй холбоотойгоор ЭМД-аас тусламж, үйлчилгээний төлбөрийн орлого багасаж, төрөөс иргэдийн анхан шатны тусламж, үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэхтэй ЭМД-ийн санхүүжилт 27,920,815.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө тайлант оны эцэст 4,723,600.7 мянган төгрөг байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ЭМС-ын 2021 оны А/31, А/474, А/326, А/553, А/643, А/504, А/799, А/766 дугаар тушаалуудаар 3,464,354.5 мянган төгрөгийн, бусад аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 1,259,246.2 мянган төгрөгийн эмнэлгийн тоног, төхөөрөмж болон бусад хөрөнгүүдийг хандиваар хүлээн авсан байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал тайлант онд 996,138.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМС-ын 2021 оны А/188, А/281, А/284, А/358, А/403, А/383, А/431, А/466, А/495, А/520, А/561, А/580, А/612, А/724, А/766 дугаар тушаалуудаар 298,386.3 мянган төгрөгийн, аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс 697,751.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад хангамжийн материалыг хандиваар хүлээн авсан байна.

Урьд онд өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийг иргэн 25.0 хувийн төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөр төлөгдөж байсан бол тайлант онд ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоол гарснаар ЭМД-аас санхүүжих болсноос шалтгаалан нормативт зардал 9,555,336.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 28,728,340.0 мянган төгрөгөөр, үүнээс бараа үйлчилгээний зардалд 28,717,080.0 мянган, урсгал шилжүүлэгт 11,260.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид саналаа хүргүүлжээ.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлээр төрийн өмчит эмнэлгүүд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжиж байгаатай холбоотойгоор бараа үйлчилгээний зардалд 33,468,549.3 мянган, урсгал шилжүүлэгт 11,260.0 мянган төгрөг буюу нийт 33,479,809.3 мянган төгрөгөөр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 33,479,809.3 мянган төгрөгийг ЭМДС-аас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 32,947.8 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн зардлыг 532,045.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний |                               | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү     | Биелэлт |
|-----|--------------------------|-------------------------------|--------------|--------------|-----------|---------|
|     | Код                      | Нэр                           |              |              |           |         |
| 1   | 71602                    | Эмнэлгийн тусламж үйлчилгээ   | 33,479,809.3 | 32,947,764.2 | 532,045.1 | 98.4    |
| 1.1 | 80101                    | Үйл ажиллагааны урсгал зардал | 33,479,809.3 | 32,947,764.2 | 532,045.1 | 98.4    |

Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар бараа ажил үйлчилгээний зардал 64,578,2 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардал 48,247.4 мянган төгрөгөөр тус тус млүү зарцуулагдсан нь Ковид-19 цар тахлын тархалттай холбоотой ор дэлгэх болон үйлчлүүлэгч нарт зориулсан тасаг, өрөөнүүдийг тохижуулах ажлыг хийсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд 50 стратеги ажлыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтэд хяналт шинжилгээ-үнэлгээ хийж, 97.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Тухайлбал:

- ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор гүйцэтгэлээр санхүүжих болсноор төсвөөс санхүүжих санхүүжилт бүрэн зогсож, үйлчлүүлэгчдээс төлөх төлбөр буурсан, орчин үеийн бай эмчилгээг даатгалын сангаас санхүүжих болсонтой холбогдуулан хими эмчилгээнд томоохон дэвшилт гарсан;
- ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарт ашигладаг эмнэл зүйн 7 программ хангамжийн хөгжүүлэлт нэвтэрснээр 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс бодит цагийн горимд шилжсэн;
- Эмчилгээ үйлчилгээнд 8 тасагт шинээр 12 технологи нэвтрүүлсэн ба элэг тайрах, хөхний мэс засал, туяа эмчилгээ, уян дурангийн ажилбар, нөхөн сэргээх мэс засал, өвдөлт намдаах зэрэг эмчилгээ оношилгоо амжилттай хэрэгжиж байгаа;
- Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажил хийгдсэн ба эхний шатны баталгаажилтын үнэлгээ амжилттай хийгдсэн;
- Төвийн эзэмшил газар 2419 м.кв талбайгаар нэмэгдсэн ба гэрчилгээ гарган баталгаажуулж хорт хавдрын эрт илрүүлэлтийн төвийн зориулалтаар ашиглах, мөн Сонгинохайрхан дүүрэгт ХСҮТ-ийн салбар 2 барих 79,997 м.кв, хавдрын сувилал барих 30,000 м.кв газруудыг тус тус холбогдох шийдвэр, гэрчилгээг гаргуулан баталгаажуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 03 дугаар “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт”, “Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам” зэргийг баталж, 2021 оны 03 дугаар сараас эхлэн мөрдөж эхэлсэн байна.

Ковидын тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг сайжруулах журам, тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай 2021 оны 67/А/268, А/337/99 дугаар хамтарсан тушаалууд, ЭМС-ын 2021 оны 02 дугаар сарын А/40 “Коронавируст халдварын оношлогоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс Коронавируст халдвартай иргэдийг хэвтэн эмчлэх 13 орыг дэлгэн ажиллуулж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 723,168.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 441,745.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу ЭМДЕГ-ын цахим системд хийгдсэн тохируулгаар нийт 807,515.0 мянган төгрөгийн зөрүү гарснаар санхүүжилт авч чадахгүй байгаа нь доорх шалтгаанаас үүдэлтэй байна. Үүнд:

- ЭМД-ийн шимтгэл төлөөгүй буюу регистрийн дугаар буруугаас 97,535.1 мянган төгрөг,
- Илүү нэхэмжилсэн, тусламж үйлчилгээ давхардсан 357,710.5 мянган төгрөг,
- Оношийн хамааралд холбогдоогүй 352,269.4 мянган төгрөг.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хавдар судлалын үндэсний төв 2021 онд нийт 175 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11,573.0 мянган төгрөгийн 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ" гэсэн заалтууд, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хавдар судлалын үндэсний төвийн эдийн засагч Д.Лхагвасүрэн, эмийн орлогын нягтлан бодогч Э.Түмэнбаяр нар 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шаардсан баримтыг хугацаанд нь гаргаж өгөөгүй, удаа дараа зөрчилтэй баримт материал ирүүлж, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан зөрчил гаргалаа.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "...аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар ... хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", гэсэн заалтын дагуу Хавдар судлалын үндэсний төвийн эдийн засагч Д.Лхагвасүрэн, эмийн орлогын нягтлан бодогч Э.Түмэнбаяр нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөх.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин, нэмэгдэл, урамшууллын тооцоолол, мөнгөн урьдчилгааны тайлан, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй байх, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь



бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах талаар өгсөн 6 зөвлөмжийн хэрэгжилт 54.7 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |                  | Биелэлт  |                 | Зөрүү    |                 |             |
|-----------------|---------------------|------------------|----------|-----------------|----------|-----------------|-------------|
|                 | Тоо                 | Дүн              | Тоо      | Дүн             | Тоо      | Дүн             | Хувь        |
| Зөвлөмж         | 6                   | 145,605.2        | 5        | 79,675.2        | 1        | 65,930.0        | 54.7        |
| <b>Нийт дүн</b> | <b>6</b>            | <b>145,605.2</b> | <b>5</b> | <b>79,675.2</b> | <b>1</b> | <b>65,930.0</b> | <b>54.7</b> |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах дараах асуудлууд байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт “Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд баримтлах удирдамж”-ын дагуу цахим системд хийгдсэн тохируулгаар гарч байгаа зөрүүг арилгасан эсэх;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолын өөрчлөлт бодит байдалтай нийцсэн эсэх;
- ЭМДЕГ-ын E-Health цахим систем болон health.gov.mn цахим системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг сайжруулж, техникийн үйл ажиллагаа хэвийн болсон эсэх.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 678,575.6 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 652,559.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 26,016.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өглөө.

##### 4.1 Албан шаардлага

1.Тайлант онд 31,972.5 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэлийг анхан шатны баримтгүй орлогод байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага өгөх.

2.Тайлант онд 620,586.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээ байгуулаагүй шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас хоногийн дараа тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэсэн заалтууд, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага өгөх.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

ХСҮТ-ийн захирал 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг 17,489,940.9 мянган төгрөгөөр баталсан боловч төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 27,914,471.2 мянган төгрөгөөр батлагдсан байна. Тус төвийн захирал зөрүүтэй батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж мөрдөөгүй, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг нэгтгэн гаргаагүй нь худалдан авалтын нэгдсэн бодлогогүй, хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтууд, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн ажиллаж, дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**2. Орлоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тайлант онд ЛХоёр ХХК-ийн анхан шатны баримтаар 15,360.0 мянган төгрөгийн эм орлогод авч Ази фарма ХХК-д өгөх өглөгөөр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**3. Авлага данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

ЭМДЕГ-аас санхүүжилт баталгаажуулахаар 2021 оны 12 дугаар сарын 10-наар тасалбар болгосноос хойш 20 хоногийн тусламж үйлчилгээний 3,087,278.3 мянган төгрөгийн орлогыг аккруэл сууриар бүртгэж авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтууд, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**4. Өглөг данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тайлант онд 10,656.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтууд, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д                                     | Байгууллагын нэр | Аудитын код             | Алдаа зөрчлийн утга   | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга   | Нийт алдаа, зөрчлийн дүн |          | Үүнээс    |     |     |     |                 |     |                   |     |         |          |
|---|------------------|-------------------------|---|--|--------------------------|----------|-----------|-----|-----|-----|-----------------|-----|-------------------|-----|---------|----------|
|   |                  |                         |   |  |                          |          | Залруулга |     | Акт |     | Албан шаардлага |     | Хариуцлага тооцох |     | Зөвлөмж |          |
|   |                  |                         |   |  | тоо                      | дүн      | тоо       | дүн | тоо | дүн | тоо             | дүн | тоо               | дүн | Тоо     | дүн      |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар |                  |                         |   |  |                          |          |           |     |     |     |                 |     |                   |     |         |          |
| 1                                       | ХСҮТ             | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | ХСҮТ-ийн захирал 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг 17,489,940.9 мянган төгрөгөөр баталсан боловч төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 27,914,471.2 мянган төгрөгөөр батлагдсан байна. Тус төвийн захирал зөрүүтэй батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж мөрдөөгүй, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг нэгтгэн гаргаагүй нь худалдан авалтын нэгдсэн бодлоггүй, хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн ажиллаж, дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх. | 1                        | 0.0      |           |     |     |     |                 |     |                   |     | 1       | 0.0      |
| 2                                       | ХСҮТ             | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | Тайлант онд ЛХоёр ХХК-ийн анхан шатны баримтаар 15,360.0 мянган төгрөгийн эм орлогод авч Ази фарма ХХК-д өгөх өглөгөөр бүртгэсэн байна.   | Өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.  | 1                        | 15,360.0 |           |     |     |     |                 |     |                   |     | 1       | 15,360.0 |

Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|  |      |                         |  |   |   |           |  |  |  |  |   |           |  |   |     |          |
|--|------|-------------------------|--|---|---|-----------|--|--|--|--|---|-----------|--|---|-----|----------|
| 3  | ХСҮТ | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | ЭМДЕГ-аас санхүүжилт баталгаажуулахаар 2021 оны 12 дугаар сарын 10-наар тасалбар болгосноос хойш 20 хоногийн тусламж үйлчилгээний 3,087,278.3 мянган төгрөгийн орлогыг аккрузал сууриар бүртгэж авлагаар бүртгээгүй байна. | Нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар хөтөлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх.   | 1 | 0.0       |  |  |  |  |   |           |  |   | 1   | 0.0      |
| 4  | ХСҮТ | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | Тайлант онд 10,656.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.  | Өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.   | 1 | 10,656.6  |  |  |  |  |   |           |  |   | 1   | 10,656.6 |
| 5  | ХСҮТ | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | Тайлант онд 31,972.5 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслийг анхан шатны баримтгүй орлогод байна.  | Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх,  | 1 | 31,972.5  |  |  |  |  | 1 | 31,972.5  |  |   |     |          |
| 6  | ХСҮТ | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | Тайлант онд 620,586.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээ байгуулаагүй шууд худалдан авсан байна.  | Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх,  | 1 | 620,586.5 |  |  |  |  | 1 | 620,586.5 |  |   |     |          |
| Дүн  |      |                         |  |   | 6 | 678,575.7 |  |  |  |  | 2 | 652,559.0 |  |   | 4   | 26,016.6 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал |      |                         |  |   |   |           |  |  |  |  |   |           |  |   |     |          |
| 1  | ХСҮТ | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | Хавдар судлалын үндэсний төвийн эдийн засагч Д.Лхагвасүрэн, эмийн орлогын нягтлан бодогч Э.Түмэнбаяр нар 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шаардсан баримтыг хугацаанд нь гаргаж өгөөгүй, удаа дараа                 | Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "...аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар ... хуулиар хориглосон үйл ажиллагаа | 1 | 0.0       |  |  |  |  |   |           |  | 1 | 0.0 |          |

Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|          |      |                         |   |  |   |           |  |  |  |  |   |           |   |     |   |          |
|----------|------|-------------------------|---|--|---|-----------|--|--|--|--|---|-----------|---|-----|---|----------|
|          |      |                         | зөрчилтэй баримт материал ирүүлж, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан зөрчил гаргалаа.   | явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, гэсэн заалтын дагуу Хавдар судлалын үндэсний төвийн эдийн засагч Д.Лхагвасүрэн, эмийн орлогын нягтлан бодогч Э.Түмэнбаяр нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөх. |   |           |  |  |  |  |   |           |   |     |   |          |
| 2        | ХСҮТ | АХГ-2022/372/НА-СТА-ТШЗ | Тайлант онд шилэн дансны цахим хуудаст нийт 11,573.0 мянган төгрөгийн ажил, гүйлгээний 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх,   | 1 | 11,573.0  |  |  |  |  | 1 | 11,573.0  |   |     |   |          |
| Дүн      |      |                         |   |  | 2 | 11,573.0  |  |  |  |  | 1 | 11,573.0  | 1 | 0.0 |   |          |
| Нийт дүн |      |                         |   |  | 8 | 690,148.7 |  |  |  |  | 3 | 664,132.0 | 1 | 0.0 | 4 | 26,016.6 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 285/А0150054

Улаанбаатар хот

АХГ-2002/372/НА-СТА-ТМЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1 заалтын дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хавдар судлалын үндэсний төвийн эдийн засагч Д.Лхагвасүрэн, эмийн орлогын нягтлан бодогч Э.Түмэнбаяр нар 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шаардсан баримтыг хугацаанд нь гаргаж өгөөгүй, удаа дараа зөрчилтэй баримт материал ирүүлж, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан зөрчил гаргалаа.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "...аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар ... хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хавдар судлалын үндэсний төвийн эдийн засагч Д.Лхагвасүрэн, эмийн орлогын нягтлан бодогч Э.Түмэнбаяр нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ХСҮТ-ийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүү, Санхүү бүртгэл, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Ц.Энхээ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Р.ЦОЛМОН







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 286/А050054

Улаанбаатар хот

АХГ-2022/372/НА-СТА-Тцз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 31,972,500.00 төгрөгийн эм, эмийн хэрэгслийг анхан шатны баримтгүй, орлогод авсан байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүү, санхүү бүртгэл, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Ц.Энхээ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Р.ЦОЛМОН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 283/А0150054

Улаанбаатар хот

АХГ-2022/372/НА-СТА ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст нийт 11,573,000.00 төгрөгийн ажил, гүйлгээний 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг хангаж, мэдээллийг цаг хугацаанд нь, үнэн зөв байршуулж байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүү, санхүү бүртгэл, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Ц.Энхээ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Р.ЦОЛМОН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 284/А0150054

Улаанбаатар хот

АХГ- 2022/372/НА-СТА-ТШВ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Тайлант онд 620,586,500.00 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээ байгуулаагүй шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүү, санхүү бүртгэл, хангамжийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Ц.Энхээ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Р.ЦОЛМОН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardлага\2022\0225\_Auditin\_2\_Gazar-290.Docx

0010800869



